



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/119

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/90 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Чагдаржавын талбайн гэрэлтүүлэг тохижилтын ажил” /ДУАОНӨГ/201704030/-ын гүйцэтгэгчээр “Тааны амт” ХХК – ийг сонгон 35,880,603 /гучин таван сая найман зуун наян мянга зургаан зуун гурав/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу ажлаа чанартай хийж гүйцэтгэхийг “Тааны амт” ХХК-ний захирал /Ю.Отгондэлгэр/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА О.ЧУЛУУНБАТ



0200350